



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/457

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг эрүүл мэндийн чиглэлээр орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Засаг даргын орлогч)

Гишүүд:

(аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, спорт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

(Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

(Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч)

(Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч)

(Эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн)

2.Улсын үзлэгийг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, тайланг нэгтгэн, дүгнэн боловсруулж холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

